

БАРИМТАТ ЗОХИОЛ  
СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ БОЛОХ НЬ

Б.Өлзийбаяр\*

\* "Түгээмэл" дээд сургуулийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

**Түлхүүр үг:** баримтат зохиол, тэмдэглэл, найруулал, нийтлэл, баримтат дүр.

**М**онголын уран зохиолын түүхэнд баримтат зохиол чухал байр суурь эзэлсээр иржээ. Ялангуяа түүх, уран зохиолын тодорхой ялгаа зааг гараагүй байх үеийн ихэнх зохиол нь баримтат зүйлийг уран яруугаар найруулан бичдэг байжээ. Иймээс хувьсгалаас өмнө Монголын уран зохиолд дорно дахины эртний уламжлал бүхий намтар цадиг, замын тэмдэглэлийн чанартай зохиол бие даасан тусгай төрөл зүйлийн байдалтай хөгжиж байв.

Ардын хувьсгалын эхэн үе, тодруулбал өнгөрсөн зууны 20-30-аад оны Монголын үргэлжилсэн үгийн зохиолд нийтлэл, найруулал, тэмдэглэл, дурдатгал зэрэг баримтад зохиол багагүй хувь эзлэж байв. Чухамдаа энэ үед өгүүллэг "үлгэрийн хэлбэрээр зохиогдож байсан"<sup>1</sup> бол баримтат

зохиолууд нь болсон үйл явдлыг тэмдэглэх чиглэлээр бичигдэж эхэлсэн байна. Ялангуяа 20-иод оны эхэн, дунд үед бичигдсэн зохиолуудыг бүхэлд нь ажиглахад голдуу тухайн үйл явдлыг албан бичгийн хэлээр болсон дэс дарааллыг чанд хатуу баримтлан тоочиж бичсэн байдал зонхилох тул тэмдэглэл дурдатгалын шинжийг илүүц хадгалсан байна. Ийм зохиолд Б.Пунцагийн "Гишүүн Пунцаг" (1928), М.Дугаржавын "Гишүүн Дугаржав" (1924) дурдатгалууд болон "Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд" (1928), "Пионер багачуудын мөрдөх дэвтэр" (1929) зэрэг эмхэтгэлд орсон зарим бүтээлийг нэрлэж болно. Эдгээр тэмдэглэл дурдатгалыг 1920-иод оны эхний үеийн Монголын нийгмийн байгууллыг нүдээр үзэж, биеэр туулсан нам засгийг байгуулалцаж, түүний үйл хэрэгт зүтгэж явсан хүмүүс бичсэн тул агуулгын талаас түүхэн үнэн зүйл юм.

Партизан Б.Пунцаг, М.Дугаржав нар дурдатгалдаа нийгмийн байдал

ардын журамт цэрэг, хувьсгалчдын үйл ажиллагаа, тэмцэл ялалт Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдлын анхны хэлхээ холбоо тэргүүтнийг өгүүлсэн байна. Тухайлбал Пунцаг гамингийнхны дунд галчаар орж ажиллан, тэдний үйл ажиллагааг тагнан мэдэж, хамт олондоо мэдэгдсэн, намын анхдугаар их хуралд төлөөлөгчөөр оролцож байсан, цагаантан болон тэдэнтэй хуйвалдагсдыг дарсан, зарим хүмүүстэй санал зөрж, энэ тухайгаа намын төв хороо, Ардын түр засгийн газарт мэдээлж байсан зэрэгцээ нэг бүрчлэн өгүүлэн бол М.Дугаржав хувьсгалт нууц бүлгэм, түүнийг удирдаж буй Д.Сүхбаатарын үйл ажиллагаа, тэднээс коминтерн ба

Оросын хувьсгалчидтай тогтоосон холбоо, үзүүлсэн тусламж дэмжлэг зэргийн тухай бичсэн байна. Энэ мэтээр Лосолын "Алтан булагт ардын түр засгийг байгуулсан тухай", Батхааны "Нийслэл хүрээ рүү хөдөлсөн нь", Догсомын "Ардын намыг анх хэрхэн үүсгэн оролцсон тухай" зэрэг дурдатгалууд ч мөн түүхэн үнэн өгүүлсэн шинжтэй юм.

Ингэж түүхэн үнэн баримтыг бичиж үлдээх явдал нь тухайн үеийн улс орны

нэгэн гол зорилт хийгээд боловсролтой зарим сэхээтний санаачлага зэрэгтэй холбоотой байлаа. Энэ үед "...хойчийн түүх зохиогчдод хэрэглэгдэх зүйлсийг биесээр оролцон явсан нөхдийн байгаад бичүүлэн хэвлэж үлдээвэл элдэвт тустайн дээр ялангуяа манай Монголын өсч буй багачуудад тун ч чухал болно"<sup>2</sup> гэж онцлон тэмдэглэсэн юм.

«

*Ийнхүү тэмдэглэн үлдээх их ажлын явц дунд зохиогчдын мэдлэг боловсрол ахиж, авьяас билэг нь өсөж байсан тул бодит байдлыг намтарчлан буулгах бус, бичих өгүүлэх зүйлээ өөр юмс үзэгдэлтэй харьцуулах, бусдаар төлөөлүүлэх зэрэг арга хэрэглэх болсон нь баримтад зохиолд уран сайхны гэрэл гэгээ тусгаж, ингэснээрээ уншигчдын урмыг сэргээх уран дүрслэл буй болгох эхлэл бий болсон байна.*

»

"Үнэхээр бичих бөгөөс дараагийн үед маш чухал болно. Одоо хувьсгал гарсаар зөвхөн долоон жил болов. Үүний хойно тавин жил болоход одоо цагийн сонин бичгийг өдрийн одон мэт болгон үзэх биш үү"<sup>3</sup> гэх зэргээр бичсэнээс үзвэл баримтат зохиол бий болсон явдал нийгэмтүүхийн шинэ зорилтоос урган гарсан

асуудал болох нь тодорхой. Ийнхүү тэмдэглэн үлдээх их ажлын явц дунд зохиогчдын мэдлэг боловсрол ахиж, авьяас билэг нь өсөж байсан тул бодит байдлыг намтарчлан буулгах бус, бичих өгүүлэх зүйлээ өөр юмс үзэгдэлтэй харьцуулах, бусдаар төлөөлүүлэх зэрэг арга хэрэглэх болсон нь баримтад зохиолд уран сайхны гэрэл гэгээ тусгаж, ингэснээрээ уншигчдын урмыг сэргээх уран дүрслэл буй болгох эхлэл бий болсон байна. Ийм хандлага нь

найруулал нийтлэлийн зохиол бие даан хөгжихийн анхны алхам болж өгчээ. Эдгээрт Улаан-оторчийн "Алтанбулагийг анх эзлэн авсан тухай" (1928), С.Буяннэмэхийн "Дайснаа дарсан Сүхбаатар" (1929), Цэндсүрэнгийн "Алсан морин дээр" (1929) зэрэг олон зохиолыг нэрлэж болно. Хорь гучаад оны найруулал нийтлэлийн гол агуулга нь дээрхи дурдатгалуудын нэгэн адил гадаад дотоодын хүнд дарлалаас ангижирч, эрх чөлөөгөө олсон монгол ард түмний тэмцлийн зориг, баатарлаг үйлсийг өргөн дэвшүүлж байв. Тухайлбал Улаан-Оторч хэмээх Ц.Дамбадоржийн "Алтанбулагийг анх эзлэн авсан тухай" найруулал хавар цагийн байгалийн хувьсал өөрчлөлтийг хүний сэтгэл санааны харьцаатай холбон дүрсэлжээ. Зохиогч монгол цэргүүдийн нэгэн үзүүрт эх оронч сэтгэл нэгдмэл хүчийг үгүйлээд Хиагтыг эзлэн авсан тулалдааныг тодорхой тайлбарлан бичсэн байна. Энэ найруулал тодорхой үйл явдалтай, товч бөгөөд хурц зураглалтай бичигдсэн нь зохиолчийн дүрслэх чадвар нилээд сайн болохыг тодорхойлж байна.

Ийнхүү Ардын хувьсгалын тухай өгүүлэмж бүхэн агуу их Октябрын хувьсгал, түүний түүхэн замнал, ач холбогдолтой ямагт хамт дүрслэгдсээр ирлээ. Монгол Зөвлөлтийн ард түмний найрамдал, Ардын хувьсгалын амжилтын тухай тодорхой баримтат тулгуурлан өгүүлэх болсон нь Октябрын хувьсгалын их удирдагч В.И.Лениний

дүрийг тодруулан гаргах үндэс болсон юм. Зохиолч С.Буяннэмэх энэ хүнтэй биечлэн уулзсанаа хувьд "Ленин" (1927), "Гайхамшигт учрал" зэрэг найруулал бичжээ. Энэ найруулалд үзэл санааны гандан буурашгүй ариун тунгалаг үйл ажиллагаа газар дэлхийд асар үнэ хүндтэй болохыг тод дүрсэлжээ. Ялангуяа Ленинтэй холбоотой зарим зүйлийг ухуулан тайлбарлах хэлбэрээр бичсэн нь дүрслэлийг тодруулж, ойлгомжийг энгийн атлаа гүнзгийрүүлж байна. Мөн "Гайхамшигт учрал" найруулалдаа Лениний дүр төрхийн гадаад байдлыг зураглан, түүний өндөр мэдлэгтэй, даруу төлөв зантай хүн болохыг нээн илэрхийлсэн байна.

Лениний дүрийг нэлээд гүн гүнзгий тусгасан өөр нэг зохиол нь Г.Навааннамжилийн "Ленин багшийн дурсгалд" (1929) шүлэг, үргэлжилсэн үгээр бичсэн нийтлэл юм. Лениний тухай эдгээр нийтлэл, найруулалд түүний үзэл санааны талыг тусган үзүүлж, хэв шинжит дүрийг бүтээсэн нийтлэг тал бий боловч С.Буяннэмэхийн зохиол зүйрлэл элбэгтэй, Навааннамжилын зохиол чимэглэл сайтай болсон нь зохиогчдын урлах эрдмийн онцлогийг харуулж байна.

Үүний зэрэгцээ Лениний дүрийг үлгэрийн баатарын хэлбэрээр урлан бүтээсэн нь бас нэг амжилт боловч Зохиолч Х.Пэрлээ "Зовлонгийн дунд гарсан чимээ" (1935) нийтлэлдээ "Ази европ тивийн уулзвар дээр гайхамшигт

их хүн аймшигтайяа их зандрахад галт бөмбөг түс хийн түймэр шатааж капиталийн төмөр торыг тасчин хаяна" гэж бичжээ. Энд аман зохиолын сэтгэмж хэрэглэсэн нь илт. Ард түмний тэмцлийн үр дүнд хувьсгалын их ялалтыг зохион байгуулж "Капиталийн төмөр торыг тасчин хаясан" тэр их хүн Ленин даруй мөн билээ. Энэ бүхэн Лениний дүрийг бүтээх уран сайхны өнгө аясыг бага ч атугай баяжуулан эрэл хийж байсны баримт болно.

**Т**үүх хувьсгалын сэдэв зонхилж байсан энэ үеийн баримтат зохиолын өөр нэг дүр нь их жанжин Д.Сүхбаатар юм. С.Буяннэмэхийн "Дайснаа дарсан Сүхбаатар" найруулалд түүний эрэмгий зориг, эр чадал, эрх чөлөөний төлөөх тэмцлийг үлгэрийн баатрын дүрээр үзүүлэхдээ "...гэнэт хажуунаас ухаа хонгор морьтой, өндөр гоёмсог биетэй, уудам сэргэлэн ухаантай, ард түмний эрх чөлөөг амь мэт хадгалах, аюултай хортон дайсанд сум мэт орох алдарт жанжин Сүхбаатар хэмээх нэгнээр гарч ирээд их хувьсгалын улаан гал бадруулсан, эрэлхэг хүчит Холбоот Улсын балт сүх далайсан баатар зоригт ардуудтай гар барилцан хүч хавсарч яах ийхийн хооронд өнөөх гамин барон, хар шар харгисуудыг устгаж, өндөр их алдарт тунгалаг их өршөөлт ардын засгийг байгуулан бүгд найрамдах улсын тулгуурыг тогтоосон" гэж түүний нийгэмд гүйцэтгэсэн өндөр үүрэг хариуцлага, гавьяа зүтгэл, Монгол Зөвлөлтийн найрамдлыг үндэслэгч

гэдгийг тодруулсан бол Ц.Дамбадорж "Алтанбулагийг анх эзлэн авсан тухай"-даа "Сүхбаатар жанжин царай харлаг, хөх дээлтэй, өрөөсөн сугандаа буу зүүжээ" гэж түүний гадаад дүр төрхийг дүрсэлсэн байна. Сүхбаатарын дүрийг ийнхүү түүнтэй цуг ойр дотно ажиллаж байсан эдгээр хүмүүс дүрслэн бичихдээ түүний ард түмнийхээ өмнө байгуулсан гавьяа зүтгэлийг нь өндөрт үнэлэхийн зэрэгцээ өгөөмөр сайхан сэтгэлтэй жирийн хүн байсан гэдгийг тодруулсан зэрэг нь нэгдмэл бөгөөд олон талтай болжээ.

Ийнхүү хорь, гучаад оны найруулал, тэмдэглэл, нийтлэл, дурдатгалын гол дүр В.И.Ленин, Д.Сүхбаатар зонхилж байгаа боловч хувьсгалч тэмцлийн ахмад зүтгэлтэн Абмад (Дамбадорж), Чой, Лосол, Догсом, С.Буяннэмэх нарын дүр ямар нэгэн хэмжээтэй дүрслэгдсэнийг тэмдэглэвэл зохино. Эдгээрт нэг талаар уг хүмүүс энэхүү түүхэн амьдралд биеээр оролцогчдын хувиас, нөгөө талаар эдгээр зохиолууд бичлэгийн арга барилын хувьд дүрслэн өгүүлэгчийн үгээр бүхий үйл явдлаа гарган илэрхийлсэнтэй холбоотой юм. Хэдийгээр түүхт хүмүүс энэ үеийн баримтат зохиолын гол дүр болж байсан боловч ихэнх зохиолын бүхий л агуулга эрх чөлөөний төлөө ард түмний шантаршгүй тэмцлийн тухай өгүүлж байсныхаа хувьд гол дүр нь тэмцэлд нягтарсан ариун цагаан сэтгэлтэй ард түмэн байлаа. Энэ үед ийнхүү түүхэн бодит үйл явдлыг үзүүлэхийн хамт зохиогчийн уран

саналын дагуу бодит амьдраалаас эх үндэстэй тодорхой үйл явдлыг хооронд нь нягт үнддүүлэн өгүүлсэн найруулал, нийтлэл цөөнгүй гарч байв.

“Дөрвөн үлгэр” хэмээх нийтлэлд зуны сайхан өдөр анчин өвгөн анд мордоод ганзага хоосон явж байтал ендер уулын орой дээр Богд баатар, Хэнтий Жонон, Цэцэрлэгт Зоригт, Тайшир дайчин дөрөв цуглараад ярилцаж байхыг сонсчээ. Цэцэрлэгт зоригтод өвгөн хамаг үхрээ мялзангаар үхүүлээд саах үнээгүй болсноо гунихран дурьдаад “Мялзан гэгч өвчний эзэн цагаан өвгөн гэгчийг олж учран, хүчээр эсэргүүцэж чадвал ор тас сөнөөгөөд, эс бөгөөс хүчийг нь муутгаж үхрээ төлүүлэн явахсан гэж үнэн сэтгэлээсээ санана” гэхэд нь Богд баатар өвгөнд манай улс мялзангийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн эдгэрүүлэхийн тулд олон живаа төгрөгийн зардал гаргаж, эрдэмтнийг урин ирүүлээд мал эмнэлгийн газар байгуулсан тухай дэлгэрэнгүй тайлбарлахын хамт хороод байхгүй мялзангийн цагаан өвгөнийг эрж явахын оронд үхэр малаа урьдчилан сэргийлэх туршлагаар таниулах хэрэгтэй гэж зөвлөж байна. Тайшир дайчин, Хэнтий Жонон хоёр Богд баатрын үгийг дэмжин байна. Ийнхүү ярилцаж байтал баруун зүгээс ааль зөөлөн, царай үзэсгэлэнтэй бөгөөд маш гоёмсог хувцастай, нум саадаг зүүсэн бүсгүй хүн хүрч ирээд “мялзанд нэрвэгдэх цаг өнгөрчээ” гээд Алтай, Хангай нутагт мал эмнэлэг байгуулагдсан тухай баяртай ярьж байна.

Жирийн анчин өвгөн тэдний сонсоод буцах замдаа арван яриаг цусан эвэртэй буга намнасан нь салаа бэлэгдлийн шинжтэй юм.

Энэ нийтлэл найруулгын гол үйл явдлыг тэр үеийн уул усаар төлөөлүүлэн өрнүүлсэн нь тухайн үеийн нийгмийн бүхий л хүрээг хамран дүрслэх гэснийх бололтой. Малаа өвчинд нэргүүлсэн аргагүй байдлаа ярилцан байтал нь мал эмнэлэг бий болсныг дуулж байгаа нь тухайн нийгэмд болсон бодит хэрэг болж улмаар зохиолын баримтлаг талыг харуулж байна. Харин мал эмнэлэг байгуулагдсан тухай өгүүлж байгаа хүнийг “Мөн гоёмсог хувцастай, нум саадаг зүүсэн бүсгүй” гэж тодорхойлсон нь шинэ хүний дүр төрхийг гадна талаас нь боловч бусдаас ялгаруулахыг оролцсон зохиолчийн санаачлага бололтой. Ийнхүү эрэл хайгуул нь “Нийтлэлийн дүрслэлтэй, сонирхолтой бөгөөд тухайн үедээ ойлгомжтой болгож байжээ”<sup>4</sup>.

Үүний нэгэн адил уран сайхны хувьд нилээд сонирхолтой бичигдсэн зохиолд Лхамжавын “Үнэхээр сонирхолтой өнгөт наран тунгалаг сарны үлгэр” (“Үнэн”, 1928, №23) хэмээх найруулал орж байна. Энэ зохиолын гол баатар Сэдэгч, Тод гэгч нэгэн залуутай уулзаж, эрдэм чадал, эр цэргийн хүчин, эдийн зүйл гурав энэ ертөнцийн амьдралыг бий болгодог гэнэ. Үүнийг хэрхэн яаж сурвал зохихыг хэлж өгөхийг хүсч байна. Тод хэмээх залуу хариулахдаа “эдийн зүйлийн тухайд мал сүргээ арчлан хамгаалах, өсгөн

үржүүлэх хадлан өвс, хашаа саравчаа бэлдэж, малаас авах сүү сааль, өөх тос, үс ноос, арьс шир зэргээс чанар сайтай бүтээгдэхүүн гарган авах, газар хагалж, үр суулгаж, өндөр ургац авах, худалдаа арилжаа хийх зэрэг ажил нь эдийн засгаа бэхжүүлэхийн эх үндэс, эрдэм боловсролтой болох нь аливаа соёлт улсын заншил бөгөөд чөлөө муутай, нас өндөр болсон, өчүүхэн бага сурснаа өндөр дээдэд бодох зэрэг нь хоосон шалтаг хийгээд биеэ боловсруулж эрдэм номд суралцах саадтай, эр цэрэг бол улсыг сахих, гадаадыг сэргийлэх, дотоодыг хамгаалах, хязгаарыг батлах зэргийн хүнд чухал үүргийг хүлээсэн юм" гэх зэргээр

тайлбарлан ярьж өгөөд "Та өөрөө үүнийг эрх биш гүйцэтгээд цааш олонд энэ мэт сануулан нэгэн адил боловсруулахыг захисугай" гэж хэлж байна.

Сэдэгчийн явсны хойно Тод зүүдэлсэн ажээ. Уг зүүдэнд нэгэн Төр гэгч айлд эрдэм нэрт, эд нэрт, эр нэгт гурван хүн ирээд хэн нь дээд талд нь суух талаар маргалдан өөр өөрсдийнхөө онцлог шинжийг магтан ярьж байна. Гэтэл эдний маргааныг Төр тасалж "Та бүхэн бардам дээрэнгүй омгоо дарж, бахархалтай эрдэм чадал юугаа илэрхийлж бэрх гүйцэтгэж" байх

хэрэгтэй гэж сануулав. Энэ үгийг гурван эр ухааран ойлгож их найр хийх болов. Тэр найранд эд нэрт эдээ ундааг бэлтгэж эрдэм нэрт үлгэр, түүх, шүлэглэлийг зохион хэлж, эр нэрт элдэв зүйлийн хүчин чадлын гайхамшгийг үзүүлсэн байна. Ингэж зүүдэлсэн Сэдэгч сэрээд би ч гэсэн энэ гурван зүйлийн эрдэмд суралцъя гээд гэртээ очиж ойр

хавийнхаа бүх хүмүүст хэлэхээр шийдэв. Болсон хэрэг явдлыг үлгэрийн зарим санаа сэдлэг, дүр дүрслэл холбон дүрсэлсэн нь баримтат зохиол аман зохиолтой нягт зууралдангуй байсныг энэхүү найруулал гэрчилж байна. Ийнхүү "Дөрвөн үлгэр"-т мал сүргээ өсгөн

«  
Ийнхүү "Дөрвөн үлгэр"-т мал  
сүргээ өсгөн үржүүлэх их бололцоо  
нээгдэж байгааг үзүүлсэн бол  
үнэхээр сонирхолтой өнгөт  
тунгалаг наран сарны үлгэрт улс  
гүрнээ цэцэглүүлэн хувь хүний  
гүйцэтгэх үүргийг өргөн  
дэвшүүлсэн байна. Үүгээрээ энэ нь  
нийгмийн шинжтэй шинэ  
асуудлыг хөндсөн нэгдмэл  
онцлогтой бүтээл болжээ.  
»

үржүүлэх их бололцоо нээгдэж байгааг үзүүлсэн бол үнэхээр сонирхолтой өнгөт тунгалаг наран сарны үлгэрт улс гүрнээ цэцэглүүлэн хувь хүний гүйцэтгэх үүргийг өргөн дэвшүүлсэн байна. Үүгээрээ эдгээр нь нийгмийн шинжтэй шинэ асуудлыг хөндсөн нэгдмэл онцлогтой бүтээлүүд болжээ. Эдгээрээс үзэхэд 20-30-аад оны нийт нийтлэл, найруулалд түүхэн үнэнийг тусгахын хамт нийгмийн энэрэл, шинэ тутам нэвтэрч байгаа дэвшилтэт арга барил (мал эмнэлэг), тусгаар тогтнох эрх чөлөөгөө олсон ард түмэн, энэ бүхнээ бататган хөгжүүлэхэд

хэрэгтэй хүчин зүйл юу болохыг тусган үзүүлэхийг зорьж байсан ажээ.

Д.Нацагдорж, Н.Наваанамжил, С.Буяннэмэх нарын нийтлэл гол баатрын яриа үзэл санааг нэгдүгээр биеэс өгүүлэх аргаар бичсэн бол Лхамжавын "Үнэхээр сонирхолтой өнгөт наран тунгалаг сарны үлгэр"-т хэд хэдэн дүрийг нэг үйл явдалд нэгтгэн нягт уялдуулан бичсэн байна.

Энэ үеийн баримтат зохиол ийнхүү дүрслэх арга барилын хувьд дэвшингүй байхын зэрэгцээ сэдвийн талаас ч бас шинэ соргог зүйлээр баяжиж байв. Үүнд их Нацагдоржийн "Хөрөнгөтний газар майн нэгнийг үзэв" гэсэн дан улс төрийн агуулгатай нийтлэл, "радио" хэмээх соёлын тухай нийтлэл, С.Буяннэмэхийн "Шив шинэхэн цуурай" хэмээх ангийн сэдэвт, Ч.Долгорсүрэнгийн "Би биш" гэдэг шинэ тутам хөгжиж буй соёлын тухай тэмдэглэл, нийтлэлүүд бичигдсэн явдал юм. Д.Нацагдорж нийтлэлдээ хөрөнгөт нийгмийн мөн чанарыг уудлан илрүүлсэн бол С.Буяннэмэх эрх чөлөөт эх орондоо ажилчин анги үүсэн бий болох нөхцөл, энэ нөхцөл хэрхэн бүрэлдэн тогтсон тухайг нам засгийн бодлого зорилго, ЗХУ-ын тусламж дэмжлэгтэй холбон өгүүлсэн байна. Ч.Долгорсүрэнгийн тэмдэглэлд ардын цэнгэлдэх төв театрын байр байдал, үзвэр үйлчилгээний тухай бичсэн нь бас л ухуулгын шинж байдалтай юм.

30-аад оны үед баримтат зохиолд нийгэм-улс төрийн асуудал тусгагдах

болсон нь бас нэгэн ололт байлаа. Үүнд Х.Пэрлээгийн "Энэ газрын орчим эрэлхэг сүргийг илэрхийлсээр ирлээ" (1936), Го.Лхагваагийн "Сайн эрийн зориг, муу эрийн шантрал" зэрэг нийтлэл, тэмдэглэлд Японы эсрэг хил хязгаараа нүдний цөцгий мэт хамгаалан харж байгаа эх оронч цэрэг эрсийн зориг, баатарлаг сонор сэргэг байдлыг өгүүлэхийн зэрэгцээ Японы түрэмгийлэгчдийн хорт бодлого, муу санааг илчлэн шүүмжилж байв. Пэрлээгийн нийтлэлд энэ тэмцэл бол Сүхбаатар жанжнаас үлгэр дууриалал авсан уламжлалтай гэж өгүүлсэн бол Лхагваагийн тэмдэглэлд хилчин Гонгорын үйл ажиллагааг шууд бичсэн байна. Мөн С.Буяннэмэхийн "Цоожтой, та байз" шог найруулал, Чимидийн "Өдрийн тэмдэглэлийн дэвтэр" шог хошин нийтлэл гарч байсныг тэмдэглэвэл зохино. Мөн энэ үед баримтат зохиол төрөл зүйлийн хувьд улам баяжиж Ц.Дамбадоржийн "Толбо нуур" (1924), Г.Навааннамжилын "Өвгөн бичээчийн өгүүлэл" (1940) зэрэг баримтат дурсамж туужууд бичигдсэн юм. Харин хорь гучаад оны баримтат зохиол амьдралын үнэнийг хэт хуулбарласан, төрөл зүйлийн хооронд нарийн ялгаа гарч чадаагүй (найруулал, нийтлэл, тэмдэглэл, сурвалжлага) дүрийг нэгэн байдлаар тоочиж бичих зэрэг дутагдал, оршиж байсан юм.

Гэвч тухайн нийгмийн шинжтэй асуудлыг дэвшүүлэн тавьж, амьдралд гарсан шинэ үзэгдлийн мөн чанарыг ухуулан сурталчилж, шинэ хуучны

зөрчил тэмцлийн үр дүнд хуучны хоцрогдлын мөхөх тавиланг илрүүлж, хүн ардад ойлгуулж байснаараа энэ үеийн баримтат зохиол агуулгын талаас ухуулан таниулах, сурталчлах байдалтай, үүгээрээ ч орчин үеэ тусгасан шинжтэй байна.

Уран сайхны талаас үлгэрчлэн бичих хэлбэр зонхилох боловч амьдралын жирийн үйл явдлыг үзүүлж байсан ажээ. Үүгээрээ ч 20-30-аад оны найруулал, нийтлэл, тэмдэглэл, тууж зэрэг нь Монголын орчин үеийн уран зохиолд баримтат зохиол үүсэх үндэс суурийг тавьсан юм.

### Ишлэл

<sup>1</sup> 1928. Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ., 43 дахь тал.

<sup>2</sup> "Хувьсгалт залуучуудын явдал" сэтгүүл. 1928, №13.

<sup>3</sup> 1928. Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ., 43 дахь тал.

<sup>4</sup> Ж а м с р а н ж а в Р. 1969. Анхны алхам. УБ., 195 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Ж а м с р а н ж а в Р. 1969. Анхны алхам. УБ.
2. 1928. Монгол ардын хувьсгалт намын түүхэнд холбогдол бүхий зүйлүүд. УБ.
3. 1968. Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. УБ.
4. "Үнэн" сонин.
5. "Хувьсгалт залуучуудын эвлэл" сэтгүүл.

### Резюме

В статье рассматриваются вопросы о возникновении первых документальных произведений в монгольской литературе. Автор приходит к выводу, что в 20-30-х годах в монгольской периодике особое место занимали такие жанры журналистики, как очерк, путевые заметки, воспоминания и репортажи. Также в эти годы была опубликована первая документальная повесть "Толбо нуур" Ц.Дамбадоржа. Первые документальные произведения в монгольской периодике относятся к художественно-публицистическим жанрам, поэтому они являются неотъемлемой частью художественной литературы. Главными представителями этого жанра являлись С.Буяннэмэх, Д.Нацагдорж, Г.Навааннамжил, Д.Чимид, Х.Пэрлээ, М. Дугаржав и Б.Пунцаг.